

Биеийн тамир спортын газрын даргын
2019 оны 12 дугаар сарын 20 –ны өдрийн
68 дугаар тушаалын 1 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ ЮА0035 9033653

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Дундговь аймгийн биеийн, тамир спортын газар

Албан тушаалын нэр:

Волейболын дасгалжуулагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮ-6

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 7-р баг, бага тойруу 4-405

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Аймгийн хэмжээнд волейбол, хөл бөмбөг, ширээний теннисний спортын дунд хугацааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах спортын холбоо, клуб, багш, арга зүйч, дасгалжуулагчдыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж ажиллах

Албан тушаалын зорилт:

1. Багууллагын стратег төлөвлөгөө болон төрөөс баримтлах бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг зохион байгуулах
 2. Волейбол холбоо, клубын болон бусад спортын холбоо, клубын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж багш, дасгалжуулагч нарыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж уялдаа холбоотой ажиллах.
 3. Волейболын секц, дугуйлан хичээллүүлж тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх
1. Дотоод ажил, ёс зүйн гэрээг мөрдөн ажиллах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1 Биеийн тамир спортын хөгжилд судалгаа дүгнэлт хийж, бодлогын баримт бичиг боловсруулах, сурталчлах хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах.	Бодлогын хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	1.2 Биеийн тамир, спортын тухай хууль түүнд нийцүүлэн төрийн захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм журам, стандартуудын биелэлтийг хангаж ажиллах	Судалгаа дүгнэлт хийж, тайлагнасан байна. Хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцон тайлагнасан байна.	Г
	1.3 Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр, жилийн ажлын тайланг 12-р сарын 15-ны дотор гарган дүгнүүлэх	Хамтын ажиллагааны үр дүн нэмэгдсэн байна.	Г
	1.4 Байгууллагаас гарч байгаа тайланд өөрийн ажил үүрэгт холбогдолтой заалт оруулах	Сургалт зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан байна.	Г
	1.5 Хариуцсан ажлын чиглэлээр тайлан мэдээг тухай бүр гаргах	Хэрэгжилтийг хангаж, үр дүнг нэгтгэсэн байна.	Х, Г
	1.6 Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, бодлого боловсруулахад шаардлагатай судалгаа, материалыг анхан шатны нэгжээс авах, дүгнэлт хийх, холбогдох газарт мэдээлэх.	Арга зүйн удирдлагаар хангасан байна.	Х, Г
	1.7 Ард иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор спортын		

	уралдаан тэмцээнийг зохион байгуулах		
2 дугаар зорилтын хүрээнд	2.1 Спорт холбоодуудын үйл ажиллагааг дэмжиж, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж хэрэгжилтэнд хяналт тавих	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	2.2 Хөл бөмбөг, ширээний теннисний холбоо, клуб-үүдтэй хамтран ажиллах тэдний үйл ажиллагааг дэмжиж ажиллах, тэндээс төрөн гарсан зэрэг цолтой тамирчдыг бүртгэх тайлан мэдээг нэгтгэх	Хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцон тайлагнасан байна. Мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан байна.	Г Г
	2.3 Багш дасгалжуулагч, сумдын арга зүйч, биеийн тамирын багш нарт мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж тэдэнд сургалт, семниар зохион байгуулах	Судалгаа, дүгнэлт хийж үр дүнг тайлагнасан байна. Спортын холбоодын үйл ажиллагааг уялдуулан зохицуулсан байна.	Г Г
	2.4 Тэмцээн уралдааныг батлагдсан удирдамж хуваарын дагуу зохион байгуулж явуулах		Г,Т
	2.5 Тэмцээн уралдааны хуваарыг жилээр гаргаж батлуулах		
3 дугаар зорилтын хүрээнд	3.1 Волейболын спортын секц дугуйлан ажиллуулах хөтөлбөр боловсруулж газрын даргаар батлуулах	Ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажилласан байна.	Г
	3.2 Волейболын спортын секцийн хичээллүүлж, улс, бүсийн чанартай тэмцээнд уралдаанд тамирчдыг амжилттай оролцуулах	Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.	Г
	3.3 Тамирчдын ур чадварт онцгой анхаарч чансаа өндөр, зэрэг цолтой тамирчин төрүүлэн гаргах.	Журам, заавар, стандартыг мөрдөн ажилласан байна.	Г Г
	3.4 Үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлж, тамирчдын амжилтыг олон улсын түвшинд хүргэх	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна.	Г
	3.5 Волейбол, хөл бөмбөг, ширээний теннис-ний спортын төрлөөр өсвөр, насанд хүрэгчдийн аймгийн аварга		

	шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>3.1 Байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах.</p> <p>3.2 Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмыг мөрдөж ажиллах.</p> <p>3.3 Ёс зүйн дүрэм, журам, гэрээг мөрдөн ажилласан байх. /Удирдлага, ажилтан албан хаагч, иргэд үйлчлүүлэгчтэй харилцах, харилцаа/</p> <p>3.4 Хариуцсан ажил албан үүрэгтэй холбоотой болон бусад чиглэлээр бүтээлч ажил, шинийг санаачлах, туршлагыг нэвтрүүлсэн байх.</p> <p>3.5 Байгууллагын дарга болон ахлах мэргэжилтний өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлсэн байх.</p> <p>3.6 Ажлын төлөвлөгөөг жил, улирал, сараар боловсруулан батлуулж, тайлагнасан байх.</p> <p>3.7 Ээлжийн амралт болон шаардлагатай тохиолдолд бусад ажилтны ажил үүргийг түр орлон гүйцэтгэх, ажлаа албан ёсоор хүлээлгэн өгсөн байх.</p> <p>3.8 Олон нийтийн ажилд идэвхитэй оролцсон байх.</p> <p>3.9 Газрын вэб сайт, 7 хоногийн ажлаа тоймлон бичиг хэрэгт өгөх мэдээллийн самбарт зохион байгуулсан ажлын тайлан мэдээг тухай бүр тогтмол байршуулсан байх.</p>		

	<p>байгууллагын самбарын мэдээллийг шинэчлэсэн эсэхэд хяналт тавих, бүртгүүлжүүлсэн байх.</p> <p>3.10 Able, программын ашиглалтыг сайжруулсан байх.</p> <p>3.11 Ажлын цагийг баримтлах, цаг ашиглалтыг сайжруулсан байх.</p> <p>3.12 Удирдах ажилтнаас томилсон ажлын хэсэгт идэвхи санаачлагатай ажиллан, төлөвлөгөө, тайланг тайлагнасан байх.</p> <p>3.13 Баримт бичгийн боловсруулалтад албан хэрэг хөтлөлтийн стандарт монгол хэл бичгийн болон найруулга зүйн хэм хэмжээг баримталж ажилласан байх.</p> <p>3.14 Хөтлөх хэргийг нэрийн жагсаалтад заасны дагуу холбогдох баримтыг архивт цаг хугацаанд хүлээлгэн өгөх.</p> <p>3.15 Өргөдөл гомдлын дэвтрийг үнэн зөв, тогтмол хөтөлж, улирал бүр мэдээг газрын даргад танилцуулах.</p> <p>3.16 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, шалгаруулахад оролцох бүрт болон захиргааны акт гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө буюу ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тохиолдолд "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг тухай бүр газрын ЭБАТ-д гаргаж өгсөн байх.</p>		
--	--	--	--

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	Биеийн тамирын арга зүйч, багш, биеийн тамирын боловсрол, спортын дасгалжуулагч,		
Мэргэшил	-Төрийн албаны мэргэшүүлэх, богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. -Спортын цол зэрэгтэй байх.		
Туршлага	Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бүтээлч, санаачлагатай ажиллах; - бусад 	
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - нээлттэй, шударга байх; - бусад 	

	Бусад	<ul style="list-style-type: none"> - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - НҮБ-аас зөвшөөрөгдсөн албан ёсны 6 хэлний аль нэгнээс ахисан түвшний мэдлэгтэй байна.
--	-------	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Биеийн тамир, спортын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр:

Байхгүй

Бусад харилцах субъект :

- БСШУСЯ-ны хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын холбогдох албан тушаалтан;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны холбогдох албан тушаалтан;
- Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан;
- Сумдын болон багийн Засаг дарга;
- Төрийн болон төрийн бус байгууллага;
- Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Хүний нөөц, хяналт шинжилгээ – үнэлгээ, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн:

Б.Дашбилэг Б.ДАШБИЛЭГ

2019 оны 12 дугаар сарын 20 ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 2019-12-20

Дугаар: 1

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан

Байгууллагын нэр:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА  М.НАРАНБАДРАХ



2019 оны 12 дугаар сарын 12 ны өдөр